

Бэлэг

Нэгэн байгууллага K төрлийн N тоглоом худалдан авч ажилтнуудынхаа хүүхдэд бэлэглэхээр болжээ. Харамсалтай нь дэлгүүрт бүх төрлийн тоглоомоос ижил тоотой байгаагүй улмаас тоглоом бүр харилцан адилгүй тоотой иржээ. Тиймээс байгууллагын нярав танаас k төрлийн бүх тоглоомыг агуулсан бэлэг хамгийн ихдээ хэчнээнийг бэлтгэж болохыг тооцоолж өгөхийг хүслээ. Түүнд тусална уу.

Оролт: Эхний мөрд N ба K тоо байна. Дараагийн мөрүүдэд сул зайгаар эсвэл мөр шилжих тэмдгээр тусгаарлагдан $[1, K]$ завсраас утга авах N ширхэг тоо өгнө. $1 \leq K \leq 1,000$; $N \leq 2,000,000,000$

Гаралт: Бүх тоглоомыг агуулах хамгийн их бэлэгний тоо болох ганц бүхэл тоо

Нийт шийдийн 30 хувьд $k \leq 10$ байна.

Жишээ:

Оролт:

8 3

1 1 2 3 1 2 3 2

Гаралт: 2

Тайлбар 1, 2, 3 төрлийн тоглоом бүхий бэлэг 2 бэлтгэж болно.